

ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ДААТГАЛЫН САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

- 1.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ
- 1.2 ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ
- 1.3 ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ
- 1.4 ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО
- 1.5 ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР
- 1.6 ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН
- 1.7 ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА
- 1.8 ДААТГАЛЫН НӨӨЦ САН
- 1.9 ДАВХАР ДААТГАЛ

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЕРДИЙН ДААТГАЛ

- 2.1 ЕРДИЙН ДААТГАЛ
- 2.2 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ
- 2.3 ЕРДИЙН ДААТГАЛЫН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ
- 2.4 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО
- 2.5 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР
- 2.6 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН
- 2.7 ЕРДИЙН ДААТГАЛЫН АШИГТ АЖИЛЛАГАА
- 2.8 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН
- 2.9 ЕРДИЙН ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ
- 2.10 ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТАЛААР

ГУРАВДУГААР БҮЛЭГ. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

- 3.1 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ, ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ
- 3.2 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ОРЛОГО, НӨХӨН ТӨЛБӨР
- 3.3 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН АШИГ, НӨӨЦ САН

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

- 4.1 ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ
- 4.2 ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ
ДҮГНЭЛТ

ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН 2013 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ДААТГАЛЫН САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2013 оны 1 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр 17 даатгалын компани, 2438 даатгалын төлөөлөгч, 18 даатгалын зуучлагч, 10 даатгалын хохирол үнэлэгч, 15 актуарч, нийт 2717 даатгалын тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчид үйл ажиллагаа явуулсан байна (Хүснэгт-1).

Хүснэгт-1

Даатгалын зах зээл дээрх тусгай
зөвшөөрөл, эрх эзэмшигчид, тоогоор

№	Үзүүлэлт	2011-01	2012 -01	2013-01
1	Даатгагч	17	18	17
2	Даатгалын компанийн салбар	139	190	219
3	Даатгалын төлөөлөгч	1592	2079	2438
4	Даатгалын зуучлагч	9	10	18
5	Даатгалын хохирол үнэлэгч	7	9	10
6	Актуарч	12	15	15
	БҮГД	1776	2321	2717

Хорооны 2013 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор “Жонон даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Хорооны 2013 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 28 дугаар тогтоолоор “Ашид билгүүн” ХХК-д даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож, Хорооны 2013 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 92 дугаар тогтоолоор “Эс Ай Би Эс” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус олгосон байна.

График-1




Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулахаар тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд, хувь хүмүүсийн тоо 2009 оны 1 дүгээр улирлаас хойш 1401 тусгай зөвшөөрөл эзэмшигчдээр өссөн байна. (График-1).

1.2 ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

2013 оны 1 дүгээр улирлын байдлаар даатгалын зах зээл дээр урт хугацааны болон ердийн даатгалын үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудын нийт хөрөнгө 104.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 46.4 тэрбум төгрөгөөр буюу 1.8 дахин өссөн байна.

Сүүлийн 4 жилийн мөн үеийн байдлаарх даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ жилд дунджаар 31.0 хувиар өссөн байна. (График-2).



2013 оны 1 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн болон урт хугацааны даатгалын компаниудыг нийт хөрөнгийн хэмжээгээр жагсаахад эхний 1 компани нийт хөрөнгийн 19.4 хувийг, эхний 3 компани нийт хөрөнгийн 36.7 хувийг тус тус эзэлж байна. Энэ нь даатгалын зах зээл дэх хөрөнгийн төвлөрлийн хэмжээ өндөр байгааг харуулж байна (Хүснэгт-2).

Хүснэгт-2

Даатгалын компаниудын хөрөнгийн хэмжээ

/сая төгрөгөөр/

№	Даатгалын компаниуд	Нийт хөрөнгийн хэмжээ	Нийт хөрөнгөнд эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	6,594.3	6.3
2	Бодь даатгал ХХК	10,475.2	10.0
3	Ган зам даатгал ХХК	3,143.2	3.0
4	Мандал женерал даатгал ХХК	7,520.5	7.2
5	Жонон даатгал ХХК		0.0
6	Миг даатгал ХХК	5,869.3	5.6
7	Монгол даатгал ХХК	20,317.6	19.4
8	Гэр даатгал ХХК	2,768.2	2.6
9	Моннис даатгал ХХК	3,971.5	3.8
10	Мөнх даатгал ХХК	2,921.2	2.8
11	Номин даатгал ХХК	5,839.5	5.6
12	Нэйшнл лайф даатгал ХХК	4,781.9	4.6
13	Практикал даатгал ХХК	7,254.9	6.9
14	Тэнгэр даатгал ХХК	7,646.1	7.3
15	Соёмбо даатгал ХХК	6,110.7	5.8
16	Монре даатгал ХХК	3,876.3	3.7
17	УБ хотын даатгал ХХК	3,330.1	3.2
18	Хаан даатгал ХХК	2,418.4	2.3
	ДҮН	104,838.9	100.0

Эргэлтийн хөрөнгийн бүтэц

Эргэлтийн хөрөнгө тайлант улиралд өмнөх оны мөн үеийнхээс 19468.7 сая төгрөгөөр өсч, нийт 86862.8 сая төгрөгт хүрсэн байна.

Эргэлтийн хөрөнгийг бүтцээр нь авч үзвэл 2013 оны 1 дүгээр улиралд мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ 47659.3 сая төгрөг ба нийт эргэлтийн хөрөнгийн 54.87 хувь, богино хугацаат хөрөнгө оруулалт 22654.3 сая төгрөг буюу нийт эргэлтийн хөрөнгийн 26.08 хувь, дансны авлага 12849.5 сая төгрөг ба нийт эргэлтийн хөрөнгийн 14.79 хувь, бусад эргэлтийн хөрөнгө 3699.7 сая төгрөг ба нийт эргэлтийн хөрөнгийн 4.26 хувийг тус тус эзэлж байна. /Хүснэгт-3/

/сая төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2012-01 улирал		2013-01 улирал		Өөрчлөлт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	39,056.30	57.95	47,659.30	54.87	8,603.00	(3.08)
Богино хугацаат хөрөнгө оруулалт	18,540.50	27.51	22,654.30	26.08	4,113.80	(1.43)
Дансны авлага	8,605.50	12.77	12,849.50	14.79	4,244.00	2.02
Бусад эргэлтийн хөрөнгө	1,191.80	1.77	3,699.70	4.26	2,507.90	2.49
Эргэлтийн хөрөнгийн дүн	67,394.10	100.00	86,862.80	100.00	19,468.70	0.00


Тайлант улиралд өмнөх оны мөн үеийнхээс эргэлтийн хөрөнгөнд эзлэх мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ 3.08 пунктээр, богино хугацаат хөрөнгө оруулалт 1.43 пунктээр тус тус буурч, дансны авлага 2.02 пунктээр, бусад эргэлтийн хөрөнгө 2.49 пунктээр тус тус өссөн байна.

Даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгийн дийлэнх хэсэг буюу 80.95 хувийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, богино хугацаат хөрөнгө оруулалт эзэлж байгаа хэдий ч өмнөх жилийн мөн үеэс 4.51 пунктээр буурсан байна. Үүнд жолоочийн хариуцлагын даатгалын нөхөн төлбөрийн өсөлт нөлөөлсөн байна.

1.3 ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн бүтцийг сүүлийн 3 жилийн 1 дүгээр улирлын байдлаар дүгнэж үзэхэд 2011 оны 1 дүгээр улиралд даатгалын нөөц сан 49.5 хувийг эзэлж байсан бол 2012 оны 1 дүгээр улиралд 44.1 хувь, 2013 оны 1 дүгээр улиралд 44.0 хувь болж тус тус буурсан байна.

Даатгалын компанийн балансын нийт пассивт нөөц сангийн эзлэх хувь 2010 оноос хойш буурч, харин эзэмшигчийн өмчийн эзлэх хувь өссөн бөгөөд энэ нь нэг талаас хувь нийлүүлэгчийн хөрөнгө буюу дүрмийн сангийн өсөлт, нөгөө талаас даатгалын нөөц сангийн актуар тооцоолол хангалтгүй байгаатай холбоотой. (График-4).



*Хүснэгт-4
/Хувиар/*

Үзүүлэлт	2011-1 улирал	2012-1 улирал	2013 -1 улирал
Өр төлбөр	5.3	7.4	6.0
Нөөц сан	49.5	44.1	44.0
Эзэмшигчийн өмч	45.2	48.5	50.0
Нийт дүн	100.0	100.0	100.0

Эзэмшигчдийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх хувь 2011 оны 1 дүгээр улиралд 45.2 хувь байсан бол 2012 оны 1 дүгээр улиралд 48.5 хувь, тайлант оны мөн үед 50.0 хувь болж тус тус өссөн нь дүрмийн сангийн өсөлттэй холбоотой байна.

2011 оны 1 дүгээр улиралд өр төлбөр 5.3 хувь, 2012 оны 1 дүгээр улиралд 7.4 хувийг тус тус эзэлж байсан бол 2013 оны 1 дүгээр улиралд 6.0 хувь байна.

1.4 ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тайлант хугацаанд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн даатгагч болон урт хугацааны даатгалын компанийн нийт орлого 15859.6 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 10.7 хувиар буурсан байна. Үүнээс ердийн даатгалын хураамжийн орлого 15626.3 сая төгрөг, урт хугацааны даатгалын компанийн орлого 233.6 сая төгрөг байна.

Тайлант улиралд ердийн даатгалын компанийн давхар даатгалын хураамж 5922.5 сая төгрөг, буцаасан даатгалын хураамж 71.0 сая төгрөг, даатгалын цэвэр хураамжийн орлого 9632.8 сая төгрөгт хүрсэн байна. Урт хугацааны даатгалын компанийн хувьд давхар даатгалын хураамж 1.9 сая төгрөг, даатгалын цэвэр хураамжийн орлого 231.7 сая төгрөг байна.

2013 оны 1 дүгээр улиралд даатгалын нийт хураамжийн орлогыг ердийн болон урт хугацааны даатгалын хэлбэрээр нарийвчлан харахад өмнөх оны мөн үеийнхээс хөрөнгийн даатгал 1.0 дахин, авто тээврийн хэрэгслийн даатгал 1.1 дахин, ачааны даатгал 1.1 дахин, тэтгэврийн даатгал 1.3 дахин, хуримтлалын даатгал 1.2 хувиар, эрүүл мэндийн даатгал 5.6 хувиар, хугацаат амьдралын даатгал 1.9 дахин тус тус өсч, хариуцлагын даатгал 0.3 дахин, гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал 0.1 дахин, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 0.1 дахин, санхүүгийн даатгал 0.4 дахин, барилга угсралтын даатгал 0.6 дахин тус тус буурч, нийт дүнгээр 10.7 хувиар өмнөх оны мөн үеийнхээс буурсан үзүүлэлттэй байна. (Хүснэгт-5).

/сая төгрөгөөр/

Даатгалын хэлбэр	2012.03.31	2013.03.31	Өсөлт бууралт /хувиар/
	Даатгалын нийт хураамжийн орлого (сая.төг)	Даатгалын нийт хураамжийн орлого (сая.төг)	
1.2. Хөрөнгийн даатгал	5432.2	5478.4	100.9
1.3. Авто тээвэр хэрэгслийн даатгал	2743.9	2994.4	109.1
1.8. Агаарын хөлгийн даатгал	2620.5	1600.4	61.1
1.10. Хариуцлагын даатгал	2297.6	1670.2	72.7
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	1552.1	1422.9	91.7
1.9. Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	1866.6	1729.9	92.7
1.11. Санхүүгийн даатгал	581.6	331.9	57.1
1.5. Барилга угсралтын даатгал	324.5	125.3	38.6
1.4. Ачааны даатгал	249.4	272.7	109.3
2.1. Хугацаат амьдралын даатгал	42.5	80	188.2
2.5. Эрүүл мэндийн даатгал	19.6	109.5	558.7
1.7. Мал амьтдын даатгал			
1.6. Газар тариалангийн даатгал			
2.3. Хуримтлалын даатгал	28.5	33.6	117.9
2.4 Тэтгэврийн даатгал	8.3	10.4	125.3
ДҮН	17 767.3	15 859.6	89.3

Даатгалын хэлбэрээр авч үзвэл ердийн даатгалын хувьд хөрөнгийн даатгал, агаарын хөлгийн даатгал, ачааны даатгалууд 1.0-1.2 дахин нэмэгдсэн байна.

Урт хугацааны даатгалын эрүүл мэндийн, тэтгэврийн, хугацаат амьдралын даатгалын хураамжийн орлого харгалзан 5.6, 1.2, 1.9 дахин тус тус өссөн нь урт хугацааны даатгалын хамралт өссөнтэй холбоотой. (Хүснэгт-6)

/сая төгрөгөөр/

	Даатгалын компаниуд	Даатгалын хураамжийн орлого	Нийт орлогод эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	1,518.9	9.6
2	Бодь даатгал ХХК	1,353.2	8.5
3	Ган зам даатгал ХХК	33.1	0.2
4	Мандал женерал даатгал ХХК	917.1	5.8
5	Хаан даатгал ХХК	71.1	0.4
6	Миг даатгал ХХК	959.8	6.1
7	Монгол даатгал ХХК	5,680.2	35.8
8	Гэр даатгал ХХК	36.8	0.2
9	Моннис даатгал ХХК	1,020.9	6.4
10	Мөнх даатгал ХХК	117.3	0.7
11	Номин даатгал ХХК	671.4	4.2
12	Нэйшнл лайф даатгал ХХК	233.6	1.5
13	Практикал даатгал ХХК	560.7	3.5
14	Тэнгэр даатгал ХХК	1,027.5	6.5
15	Соёмбо даатгал ХХК	825.9	5.2
16	Монре даатгал ХХК	536.3	3.4
17	УБ хотын даатгал ХХК	296.1	1.9
	ДҮН	15,859.9	100.0

Даатгалын компаниудыг 2013 оны 1 дүгээр улиралд олсон даатгалын хураамжийн орлогын хэмжээгээр жагсаахад эхний 1 компани нийт хураамжийн орлогын 35.8 хувь, эхний 3 компани 53.9 хувийг тус тус бүрдүүлж ажилласан байна.

ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

2013 оны 1 дүгээр улиралд даатгалын компаниуд даатгуулагч иргэд, байгууллагуудад нийт 6445.2 сая төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон ба үүнээс ердийн даатгагч 6403.0 сая төгрөг, урт хугацааны даатгагч 42.1 сая төгрөгийн нөхөн төлбөрийг тус тус олгосон байна.

Тайлант үед даатгалын нөхөн төлбөрийн дүн өмнөх оны мөн үеэс 2.2 дахин өссөн нь даатгалын байгууллагын хохирол нөхөлтийн түвшинг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна. (Хүснэгт-7)

Даатгалын хэлбэр	2012.03.31	2013.03.31	Өсөлт бууралт /Хувиар/
	Даатгалын нийт нөхөн төлбөр(сая.төг)		
1.2. Хөрөнгийн даатгал	263.1	699.7	265.94
1.3. Авто тээврийн хэрэгслийн даатгал	1 485.1	1 936.8	130.42
1.8. Агаарын хөлгийн даатгал		2.1	
1.10. Хариуцлагын даатгал	37.1	44.1	1836.12
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	370.9	492.8	132.87
1.9. Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	430.0	2935.9	534.58

1.11. Санхүүгийн даатгал	294.4	249.5	84.75
1.5. Барилга угсралтын даатгал		0.1	
1.4. Ачааны даатгал	29.6	42.1	142.23
2.1. Хугацаат амьдралын даатгал		13.4	
2.5. Эрүүл мэндийн даатгал		15.6	
1.7. Мал амьтдын даатгал			
1.6. Газар тариалангийн даатгал			
2.3. Хуримтлалын даатгал		12.1	
2.4 Тэтгэврийн даатгал		1.1	
	2 910.2	6 445.2	221.5

Тайлант оны 1 дүгээр улирлын даатгалын нөхөн төлбөрийг өмнөх оны мөн үеийнхтэй хэлбэр тус бүрээр харьцуулбал ердийн даатгалаас автотээврийн хэрэгслийн даатгал, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал, гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал тус тус 1.3 дахин өсч, хөрөнгийн даатгал 2.7 дахин өсөлттэй бол урт хугацааны даатгалын хувьд хуримтлалын даатгал, хугацаат амьдралын даатгал, эрүүл мэндийн даатгалд тус тус нөхөн төлбөр олгогдож эхэлсэн байна.

2013 оны 1 дүгээр улиралд олгосон даатгалын нөхөн төлбөрийн 30.0 хувийг автотээврийн хэрэгслийн даатгалын, 45.5 хувийг жолоочийн хариуцлагын даатгалын нөхөн төлбөр тус тус эзэлж байна.

Мал амьтад, газар тариалангийн даатгал тус тус нөхөн төлбөр олгогдоогүй байна.

Хүснэгт-8

	Даатгалын компаниуд	Даатгалын нөхөн төлбөр	Нийт нөхөн төлбөрт эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	484.7	7.5
2	Бодь даатгал ХХК	621.7	9.6
3	Ган зам даатгал ХХК	51.0	0.8
4	Мандал женерал даатгал ХХК	95.7	1.5
5	Хаан даатгал ХХК	0.4	0.0
6	Миг даатгал ХХК	613.4	9.5
7	Монгол даатгал ХХК	2,012.9	31.2
8	Гэр даатгал ХХК	27.2	0.4
9	Моннис даатгал ХХК	7.8	0.1
10	Мөнх даатгал ХХК	86.8	1.3
11	Номин даатгал ХХК	589.7	9.1
12	Нэйшнл лайф даатгал ХХК	42.1	0.7
13	Практикал даатгал ХХК	497.2	7.7
14	Тэнгэр даатгал ХХК	497.7	7.7
15	Соёмбо даатгал ХХК	554.2	8.6
16	Монре даатгал ХХК	236.7	3.7
17	УБ хотын даатгал ХХК	26.1	0.4
	ДҮН	6,445.3	100.0

Даатгалын компаниудыг даатгалын нөхөн төлбөр олголтоор харьцуулахад “Монгол даатгал” ХХК 2012.9 сая төгрөг буюу нийт нөхөн төлбөрийн 31.2 хувийг эзэлж байна.

1.6 ДААТГАЛЫН ХОХИРОЛ НӨХӨЛТИЙН ХАРЬЦАА

Даатгалын хохирол нөхөлтийн харьцаа 2011 оны 1 дүгээр улиралд 33.1 хувь, 2012 оны 1 дүгээр улиралд 29.5 хувь байсан бол 2013 оны мөн үед 45.5 хувь болж өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 16.0 пунктээр нэмэгдсэн байна. (График-10).

График-10



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудын 2012 оны хохирол нөхөлтийн харьцааг 2013 оны 1 дүгээр улирлын үзүүлэлттэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт-9

Даатгалын хохирол нөхөлтийн харьцаа

№	Даатгалын компаниудын нэрс	Хохирол нөхөлтийн түвшин		Өсөлт бууралт /пунктээр/
		2012-01	2013-01	
1	Ард даатгал ХХК	24.5	34.2	9.70
2	Бодь даатгал ХХК	21.5	36.6	15.08
3	Ган зам даатгал ХХК	4.1	40.3	36.25
4	Мандал женерал даатгал ХХК	1.2	18.7	17.52
5	Жонон даатгал ХХК	0.0	1.6	1.57
6	Миг даатгал ХХК	24.9	59.5	34.52
7	Монгол даатгал ХХК	45.7	58.3	12.55
8	Гэр даатгал ХХК	3.5	31.4	27.91
9	Моннис даатгал ХХК	17.7	4.7	-13.03
10	Мөнх даатгал ХХК	5.9	27.3	21.43
11	Номин даатгал ХХК	31.5	62.1	30.59
12	Нэйшнл лайф даатгал ХХК	42.9	18.2	-24.77
13	Практикал даатгал ХХК	23.6	41.6	18.05
14	Тэнгэр даатгал ХХК	19.8	41.7	21.92
15	Соёмбо даатгал ХХК	34.8	51.6	16.86
16	Монре даатгал ХХК	23.2	50.9	27.64
17	УБ хотын даатгал ХХК	19	12.2	-6.80
	ДҮН	29.5	45.5	16.00

Даатгалын компаниудын 2013 оны 1 дүгээр улиралд олгосон хохирол нөхөлтийн харьцааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14 компанийн үзүүлэлт өсч, 3 компани буюу “Моннис даатгал” ХХК, “Улаанбаатар хотын даатгал” ХХК, “Нэйшнл лайф даатгал” ХХК-иудын харьцаа харгалзан 13.03, 24.77, 6.8 пунктээр тус тус буурсан байна.

1.7 ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

2013 оны 1 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 1103.0 сая төгрөг байна.

Тайлант улиралд ердийн даатгалын 15 компани ашигтай ажилласан бөгөөд “Миг даатгал” ХХК 235.9 сая төгрөг, “Нэйшнл лайф даатгал” ХХК 3 сая төгрөгийн тус тус алдагдалтай ажиллан нийт салбарын хэмжээний тайлант үеийн цэвэр ашгийг бууруулахад нөлөөлж байна. (Хүснэгт-10).

Даатгалын компанийн 2013 оны 1 дүгээр улирлын цэвэр ашиг (алдагдал)


№	Даатгалын компаниуд	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	Нийт ашиг /алдагдал/-д эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	151.7	13.8
2	Бодь даатгал ХХК	180.4	16.4
3	Ган зам даатгал ХХК	117.2	10.6
4	Мандал женерал даатгал ХХК	55.9	5.1
5	Хаан даатгал ХХК	(92.1)	-8.3
6	Миг даатгал ХХК	(235.9)	-21.4
7	Монгол даатгал ХХК	248.0	22.5
8	Гэр даатгал ХХК	23.8	2.2
9	Моннис даатгал ХХК	60.1	5.4
10	Мөнх даатгал ХХК	7.2	0.7
11	Номин даатгал ХХК	80.1	7.3
12	Нэйшнл лайф даатгал ХХК	(35.7)	-3.2
13	Практикал даатгал ХХК	112.8	10.2
14	Тэнгэр даатгал ХХК	150.5	13.6
15	Соёмбо даатгал ХХК	234.2	21.2
16	Монре даатгал ХХК	36.4	3.3
17	УБ хотын даатгал ХХК	8.4	0.8
	ДҮН	1,103.0	100.0

1.8 ДААТГАЛЫН НӨӨЦ САН

Даатгалын нөөц сангийн үлдэгдлийг сүүлийн 3 жилийн мөн үеийн байдлаар зэрэгцүүлж үзэхэд 2011 оны 1 дүгээр улиралд 28.8 сая төгрөг, 2012 оны 1 дүгээр улиралд 36.3 сая төгрөг, 2013 оны 1 дүгээр улиралд 45.6 сая төгрөгөөр тус тус


нэмэгдсэн байгаа хэдий ч даатгалын компанийн балансын нийт пассивт нөөц сангийн эзлэх хувь 2010 оноос хойш буурсан үзүүлэлтэй байна. График-11

/сая төгрөгөөр/



1.9 ДАВХАР ДААТГАЛ

Давхар даатгалын хураамж 2011 оны 1 дүгээр улиралд 2795.4 сая төгрөг, 2012 оны 1 дүгээр улиралд 8057.1 сая төгрөг байсан ба тайлант оны 1 дүгээр улиралд 5924.3 сая төгрөг болж буурсан байна. Өмнөх оны мөн үеийнхээс 2132.8 сая төгрөгөөр буурсан байна. Нийт давхар даатгалын 78.0 хувийг хөрөнгийн даатгал, агаарын хөлгийн давхар даатгал эзэлж байгаа бөгөөд бусад хэлбэрээрх давхар даатгалын үзүүлэлт буурсан байна.



Тайлант үеийн байдлаар даатгалын нийт хураамжийн орлогын 38.0 хувийг давхар даатгалд төлсөн хураамж эзэлж байна.

2013 оны 1 дүгээр улиралд “Ард даатгал” ХХК 148.8 сая төгрөг, “Бодь даатгал” ХХК 290.3 сая төгрөг “Мандал женерал даатгал” ХХК 496.5 сая төгрөг, “МИГ даатгал” ХХК 383.1 сая төгрөг “Монгол даатгал” ХХК 3283.7 сая төгрөг, “Номин даатгал” ХХК 32.4 сая, төгрөг, “Тэнгэр даатгал” ХХК 277.3 сая төгрөг “Нэйшнл лайф

даатгал” ХХК 1.9 сая “Соёмбо даатгал” ХХК 97.8 сая төгрөг, “Моннис даатгал” ХХК 836.6 сая төгрөг, “Практикал даатгал” ХХК 49.1 сая төгрөг, “Монре даатгал” ХХК 26.8 сая төгрөгийг тус тус давхар даатгалд төлсөн байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЕРДИЙН ДААТГАЛ

2.1 ЕРДИЙН ДААТГАЛ

2013 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 16 ердийн даатгагч үйл ажиллагаа явуулж байна. Ердийн даатгалын компанийн 219 салбар Улаанбаатар хот хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 29 салбар нэмэгдсэн байна.

2.2 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ

Энэ оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 16 даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 100.0 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд 2009 оны мөн үеэс 66.2 тэрбум төгрөгөөр буюу 51 хувиар нэмэгдсэн байна.



2.3 ЕРДИЙН ДААТГАЛЫН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Эзэмшигчийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх хувийн жин өмнөх оны мөн үеэс 8.85 пунктээр өссөн байна.

(Хүснэгт-11)

/сая төгрөгөөр/

Санхүүгийн үзүүлэлт	2012 - I		2013 - I		Өсөлт бууралт	
	тОО	эзлэх хувь	тОО	эзлэх хувь	тОО	эзлэх хувь
Эзэмшигчдийн өмч	28514.9	75.20	41458.6	84.06	12943.7	8.85
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	9402.2	24.80	7863.5	15.94	-1538.7	-8.85
Эзэмшигчдийн өмчийн дүн	37917.1	100	49322.1	100	11405	0.00

Тайлант оны 1 дүгээр улирлын эзэмшигчдийн өмчийн дүн өмнөх оны мөн үеийнхээс 12943.7 сая төгрөгөөр нэмэгдэж, хуримтлагдсан ашиг 1538.7 сая төгрөгөөр тус тус буурсан байгаа ч нийт дүнгээр 11405.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

2.4 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тайлант үед ердийн даатгалын компаниуд 15626.3 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой ажилласан бөгөөд үүнээс 5922.4 сая төгрөг буюу 37.9 хувийг давхар даатгалд, 71.0 сая төгрөг буюу 0.45 хувийг буцаасан даатгалын хураамжид төлж, 9632.8 сая төгрөгийн даатгалын цэвэр хураамжийн орлоготой ажилласан байна.

Даатгалын компаниудыг 2013 оны 1 дүгээр улиралд олсон даатгалын хураамжийн орлогоор жагсаахад нийт хураамжийн орлогын 36.4 хувь буюу 5680.2 сая төгрөгийг эхний нэг компани бүрдүүлсэн бол эхний 3 компани нийт хураамжийн орлогын 54.8 хувийг бүрдүүлж байна. (Хүснэгт-12)

	Даатгалын компаниуд	Даатгалын хураамжийн орлого	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	1,518.9	9.7
2	Бодь даатгал ХХК	1,353.2	8.7
3	Ган зам даатгал ХХК	33.1	0.2
4	Мандал генерал даатгал ХХК	917.1	5.9
5	Хаан даатгал ХХК	71.1	0.5
6	Миг даатгал ХХК	959.8	6.1
7	Монгол даатгал ХХК	5,680.2	36.4
8	Гэр даатгал ХХК	36.8	0.2
9	Моннис даатгал ХХК	1,020.9	6.5
10	Мөнх даатгал ХХК	117.3	0.8
11	Номин даатгал ХХК	671.4	4.3
12	Практикал даатгал ХХК	560.7	3.6
13	Тэнгэр даатгал ХХК	1,027.5	6.6
14	Соёмбо даатгал ХХК	825.9	5.3
15	Монре даатгал ХХК	536.3	3.4
16	УБ хотын даатгал ХХК	296.1	1.9
	ДҮН	15,626.3	100.0

/сая төгрөгөөр/

2.5 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

2013 оны 1 дүгээр улирлын байдлаар 2204.4 сая төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгожээ.

“Монгол даатгал” ХХК нийт нөхөн төлбөрийн 31.4 хувь, “Бодь даатгал” ХХК 9.7 хувь, “Миг даатгал” ХХК 9.6 хувийг тус тус бүрдүүлж нийт зах зээлийн 50.7 хувийг эзэлж байна.

(Хүснэгт-13)
/сая төгрөгөөр/

	Даатгалын компаниуд	Даатгалын нөхөн төлбөр	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	484.7	7.6
2	Бодь даатгал ХХК	621.7	9.7
3	Ган зам даатгал ХХК	51.0	0.8
4	Мандал женерал даатгал ХХК	95.7	1.5
5	Хаан даатгал ХХК	0.4	0.0
6	Миг даатгал ХХК	613.4	9.6
7	Монгол даатгал ХХК	2,012.9	31.4
8	Гэр даатгал ХХК	27.2	0.4
9	Моннис даатгал ХХК	7.8	0.1
10	Мөнх даатгал ХХК	86.8	1.4
11	Номин даатгал ХХК	589.7	9.2
12	Практикал даатгал ХХК	497.2	7.8
13	Тэнгэр даатгал ХХК	497.7	7.8
14	Соёмбо даатгал ХХК	554.2	8.7
15	Монре даатгал ХХК	236.7	3.7
16	УБ хотын даатгал ХХК	26.1	0.4
	Дүн	6,403.2	100.0

2.6 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХОХИРОЛ НӨХӨЛТИЙН ХАРЬЦАА

Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй ердийн даатгалын компаниудын даатгалын хохирол нөхөлтийн харьцааг авч үзэхэд 2013 оны 1 дүгээр улирлын байдлаар “Номин даатгал” ХХК 62.1 хувь “Миг даатгал” ХХК 59.5 хувь, “Монгол даатгал” ХХК 58.3 хувьтай буюу хамгийн өндөр хувьтай байна.

(Хүснэгт-14)

№	Компанийн нэр	Хохирол нөхөлтийн харьцаа
1	Ард даатгал ХХК	34.2
2	Бодь даатгал ХХК	36.6
3	Ган зам даатгал ХХК	40.3
4	Мандал женерал даатгал ХХК	18.7
5	Хаан даатгал ХХК	1.6
6	Миг даатгал ХХК	59.5
7	Монгол даатгал ХХК	58.3
8	Гэр даатгал ХХК	31.4
9	Моннис даатгал ХХК	4.7
10	Мөнх даатгал ХХК	27.3
11	Номин даатгал ХХК	62.1
13	Практикал даатгал ХХК	41.6
14	Тэнгэр даатгал ХХК	41.7

15	Соёмбо даатгал ХХК	51.6
16	Монре даатгал ХХК	50.9
17	УБ хотын даатгал ХХК	12.2
	ДҮН	46.0

2.7 ЕРДИЙН ДААТГАЛЫН АШИГТ АЖИЛЛАГАА

Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 1138.7 сая төгрөг бөгөөд ердийн даатгалын компаниуд нэгдсэн дүнгээр ашигтай ажилласан байна.

(Хүснэгт-15)

/сая төгрөгөөр/

№	Даатгалын компаниуд	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	Нийт ашиг алдагдалд эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	151.7	13.3
2	Бодь даатгал ХХК	180.4	15.8
3	Ган зам даатгал ХХК	117.2	10.3
4	Мандал женерал даатгал ХХК	55.9	4.9
5	Хаан даатгал ХХК	(92.1)	-8.1
6	Миг даатгал ХХК	(235.9)	-20.7
7	Монгол даатгал ХХК	248.0	21.8
8	Гэр даатгал ХХК	23.8	2.1
9	Моннис даатгал ХХК	60.1	5.3
10	Мөнх даатгал ХХК	7.2	0.6
11	Номин даатгал ХХК	80.1	7.0
12	Практикал даатгал ХХК	112.8	9.9
13	Тэнгэр даатгал ХХК	150.5	13.2
14	Соёмбо даатгал ХХК	234.2	20.6
15	Монре даатгал ХХК	36.4	3.2
16	УБ хотын даатгал ХХК	8.4	0.7
	ДҮН	1,138.7	100.0

“Хаан даатгал” ХХК 92.1 сая төгрөгийн, “Миг даатгал” ХХК 235.9 сая төгрөгийн тус тус цэвэр алдагдалтай ажиллаж 328.0 сая төгрөгөөр даатгалын салбарын цэвэр ашгийг бууруулсан байна.

2.8 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН

2013 оны 1 дүгээр улирлын байдлаар даатгалын нөөц сангийн үлдэгдлийн 28.0 хувийг учирч болзошгүй хохирлын нөөц сан, 53.0 хувийг орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан, 0 хувийг нэхэмжилсэн хохирлын нөөц, 17.0 хувийг учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан, 2.0 хувийг тусгайлсан нөөц сангууд эзэлж байна. (Хүснэгт-16)

/сая төгрөгөөр/

Нөөц сан	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан	28087.9	8542.0	12799.4	23830.6

Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан	7748.4	2830.1	3005.7	7572.8
Нэхэмжилсэн хохирлын нөөц сан	221.8	6517.1	6683.3	55.6
Учирч болзошгүй нөөц сан	11721.2	1458.7	657.4	12522.6
Тусгайлсан нөөц сан	936.5			936.5
ДҮН	48715.7	19347.9	23145.7	44917.7

Хорооны 2012 оны 389 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын нөөцийн сан бүрдүүлэх зарцуулах журам”-д заасан аргачлалаар байгуулсан учирч болзошгүй хохирлын нөөц сан нийт нөөцийн сангийн 28.0 хувийг эзэлж байна.

2.9 ЕРДИЙН ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ

2013 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 5922.3 сая төгрөгийг давхар даатгалд төвлөрүүлсэн байна. “Монгол даатгал” ХХК 55.45 хувийг дангаараа эзэлж байна.

(Хүснэгт-17)

№	Даатгагчийн нэр	Давхар даатгалын хураамжийн орлого	/сая төгрөгөөр/
			Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	148.8	2.51
2	Бодь даатгал ХХК	290.3	4.90
3	Тэнгэр даатгал ХХК	277.3	4.68
4	Практикал даатгал ХХК	49.1	0.83
5	Миг даатгал ХХК	383.1	6.47
6	Монгол даатгал ХХК	3283.7	55.45
7	Номин даатгал ХХК	32.4	0.55
8	Мандал женерал даатгал ХХК	496.5	8.38
9	Соёмбо даатгал ХХК	97.7	1.65
11	Ган зам даатгал ХХК		0.00
12	Моннис даатгал ХХК	836.7	14.13
13	Монре даатгал ХХК	26.7	0.45
	Дүн	5922.3	100.00

2.10 ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТАЛААР

2013 оны 3 дугаар 31-ний өдрийн байдлаар нийт 15.6 тэрбум төгрөгийн даатгалын хураамж даатгалын компаниудад төвлөрсөн ба үүнээс 1.7 тэрбум төгрөг нь жолоочийн хариуцлагын даатгалын хураамжийн орлого байна. Мөн даатгалын компаниуд нийт 6.5 тэрбум төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон ба үүнээс 2.9 тэрбум төгрөг нь жолоочийн хариуцлагын даатгалын нөхөн төлбөр байна.

2013 оны 3 дугаар 31-ний өдрийн байдлаар жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нийт 29,844 гэрээ байгуулагдаж, даатгагчаас 5,952 даатгуулагчийн бусдад учруулсан хохиролд нөхөн төлбөр олгосон.

2013 оны 1 дүгээр улирлын байдлаарх жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж, нөхөн төлбөрийг компаниар задлан харвал дараах байдалтай байна:

Даатгалын компани	Жолоочийн даатгалын хураамж	/сая төгрөгөөр/
		Жолоочийн даатгалаар олгосон нөхөн төлбөр
1."Ард даатгал" ХХК	193.2	232.9
2."Бодь даатгал" ХХК	269.8	400.0
3."Ган зам даатгал" ХХК	-	8.4
4."Гэр даатгал" ХХК	32.2	24.3
5."Мандал женерал даатгал" ХХК	54.9	46.7
6."Миг даатгал" ХХК	163.9	303.2
7."Монгол даатгал" ХХК	321.7	638.8
8."Моннис даатгал" ХХК	3.6	-
9."Монре даатгал" ХХК	174.3	174.4
10."Мөнх даатгал" ХХК	28.1	73.3
11."Номин даатгал" ХХК	1.8	296.2
12."Практикал даатгал" ХХК	116.8	145.2
13."Соёмбо даатгал" ХХК	243.6	309.6
14."Тэнгэр даатгал" ХХК	115.9	281.1
15."Улаанбаатар хотын даатгал" ХХК	0.8	1.8
16."Хаан даатгал" ХХК	9.0	-
Нийт	1,729.9	2,935.9

2013 оны 1 дүгээр улирлын байдлаарх жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамжийг 2012 оны мөн үетэй харьцуулж үзвэл даатгалын хураамж ойролцоо түвшинд байгаа бол даатгалын нөхөн төлбөр 2.5 тэрбум төгрөгөөр буюу 7 дахин өссөн байдалтай байна. Цаашид нөхөн төлбөрийн хэмжээ тогтмол өсөх хандлагатай байна.

Жолоочийн даатгалын сангийн тухай

2013 он 1 дүгээр улирлын байдлаар Албан журмын даатгагчдын холбоо нь нийт 358.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, үүнээс Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.1 дэх заалтын дагуу жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа 15 даатгалын компаниас 282.8 сая төгрөг, мөн хуулийн 22.1.4 дэх заалтын дагуу автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвараар Өмнөговь, Архангай, Хөвсгөл, Сэлэнгэ, Орхон, Баян-Өлгий аймгуудаас 71.1 сая төгрөг болно.

2013 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар даатгалын компаниудаас 473.7 сая төгрөг, орон нутгаас 94.0 сая төгрөг жолоочийн даатгалын санд төвлөрсөн байна.

Жолоочийн даатгалд хамрагдаагүй, эсхүл гэрээний хугацаа дууссан, түүнчлэн даатгалын тохиолдол гаргасан жолооч зугтаасан болон даатгагч нь дампуурсан зэрэг тохиолдолд жолоочоос бусад этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх зорилготой жолоочийн даатгалын сангаас хуульд заасны дагуу 2013 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нөхөн төлбөр олгож эхэлсэн.

2013 он 1 дүгээр улирлын байдлаар Албан журмын даатгагчдын холбооны жолоочийн даатгалын санд хамаарах 16 даатгалын тохиолдол гарсан. Үүний улмаас

бусдад тус бүр нь 70.0-850.0 мянган төгрөгийн хохиролтой, нийт 10.2 сая төгрөгийн хохирол учирсан. Үүнээс 15 тохиолдолд нь талууд хоорондоо тохиролцож, буруутай этгээд 100 хувь хохирлыг барагдуулж, үлдэх 1 тохиолдлын 595.0 мянган төгрөгийн хохирлыг жолоочийн даатгалын сангаас хохирсон этгээдэд барагдуулж, сан олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс нэхэмжлэх эрхийг шилжүүлэн авсан байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

3.1 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ, ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Даатгалын зах зээл дээр “Нэйшнл лайф даатгал” ХХК нь урт хугацааны даатгалын үйл ажиллагааг 2008 оноос хойш явуулж байна.

Тус компанийн хөрөнгийн хэмжээ 2011 оны 01 дүгээр улирлын байдлаар 2078.1 сая төгрөг, 2012 оны мөн үеийн байдлаар 3560.0 сая төгрөг 2013 оны мөн үеийн байдлаар 4781.9 сая төгрөгт хүрч, жил бүр нэмэгдэж ирсэн байна. /График-9 /
/сая төгрөгөөр/



3.2 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ОРЛОГО, ДАВХАР ДААТГАЛ

Урт хугацааны даатгалын компани 2013 оны 1 дүгээр улирлын байдлаар 233.6 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой ажиллаж, 1.9 сая төгрөгийг давхар даатгагчид төвлөрүүлж, 42.0 сая төгрөгийг даатгалын нөхөн төлбөрт төлжээ. Сүүлийн 2 жилийн мөн үеийн байдлаар орлого, давхар даатгал, нөхөн төлбөрийн үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулбал:

(Хүснэгт-19) /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2012-1	2013 -1	Өөрчлөлт
----------	--------	---------	----------

Хураамжийн орлого	98.9	233.6	134.7
Давхар даатгал	2.5	1.9	-0.6
Нөхөн төлбөр	41.4	42.0	0.6

Өмнөх оны мөн үеийнхээс хураамжийн орлого 134.7 сая төгрөгөөр, нөхөн төлбөр 0.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, давхар даатгал 0.6 сая төгрөгөөр буурсан байна.

3.3 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН АШИГТ АЖИЛЛАГАА, НӨӨЦ САН

Урт хугацааны даатгагч нь 2008 оноос хойш алдагдалтай ажилласаар ирсэн бөгөөд нийт хуримтлагдсан алдагдлын хэмжээ 668.5 сая төгрөгт хүрсэн байна.

(Хүснэгт-20) /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2012-1	2013 -1	Өөрчлөлт
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-668.5	-770.3	101.8
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	-21.8	-35.7	13.9
Нөөц сан	313.8	704.5	390.7

Өмнөх оны мөн үеийнхээс хуримтлагдсан алдагдал 128.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

(Хүснэгт-21) /сая төгрөгөөр/

Даатгалын нөөц	2012-1	2013 -1	Өөрчлөлт
Хувь оролцоотой гэрээний нөөц сан			
Хувь оролцоогүй гэрээний нөөц сан	313.8	704.5	390.7
Хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сан			
ДҮН	313.8	704.5	390.7

Даатгалын нөөц сан 2013 оны 1 дүгээр улирлын байдлаар 704.5 сая төгрөг байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 390.7 сая төгрөгөөр буюу 44.5 хувиар өссөн байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

4.1 ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ

Тайлант оны 1 дүгээр улиралд нийт 18 даатгалын зуучлагч компани үйл ажиллагаа явуулж тайлангаа ирүүлсэн байна. Үүнээс 10 даатгалын зуучлагч орлоготой ажилласан бөгөөд үлдсэн нь үйл ажиллагааны орлого төвлөрүүлээгүй байна. Тайлант улиралд даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын даатгалын зуучлалын ажиллагааны орлого 207.2 сая төгрөг болсон байна.

№	Компанийн нэр	Даатгалын зуучлалын орлого		Өсөлт бууралт /хувиар/
		2012-1	2013 -1	
1	“Асимон брокерс” ХХК	8.9	24.3	273
2	“АМЕ” ХХК	67.1	23.8	35
3	“Ачит ундарга” ХХК	10.6	9.9	93
4	“Лоялти солюшн” ХХК	10.4	1.9	18
5	“Эм Жи Ай Би” ХХК	4.5	0	-
6	“Юу ай би” ХХК	0	7	-
7	“Ренессанс групп” ХХК	17.1	6.7	39
8	“Жомолхари” ХХК	2.1	0	-
9	"Нэйшнл эженси" ХХК	0	6.8	-
10	Хаан банк ХХК		94.9	-
11	Си эн эн икс		29.3	-
12	Гэрэлт буян ундрах		2.6	-
	Нийт дүн	120.7	207.2	171

Тайлант оны зуучлалын орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад Аме” ХХК 65 хувиар, “Лоялти солюшн” ХХК 72 хувиар, “Ачит ундарга” ХХК 7 хувиар, “Ренессанс групп” ХХК 61 хувиар тус тус буурч, Асимон брокерс” ХХК 2.73 дахин өссөн байна.

4.3 ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

Тайлант улиралд даатгалын хохирол үнэлэгч компаниудын нийт орлого 154.8 сая төгрөг болсон байна. Үүнээс даатгалын хохирол үнэлэгчийн орлого нийт орлогын 56.0 хувь буюу 86.8 сая төгрөг төвлөрүүлж, үлдсэн 44.0 хувийг бусад орлого эзэлж байна.

№	Компанийн нэр	Даатгалын хохирол үнэлгээний орлого		Өөрчлөлт хувиар
		2012-1	2013 -1	
1	“Бест эстимэйт” ХХК	1.7	7.9	465
2	“Гэрэгэ эстимэйт” ХХК	6.1	25.6	420
3	“Файн эстимэйт” ХХК	0.2	0.3	150
4	“Итгэлт эстимэйт” ХХК	0	11.2	-
5	“Мега марз” ХХК	0	0	-
6	“Вендо” ХХК	6.7	26.4	3.94
7	“Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК	0.03	0.1	333
8	"Арвижих эстимэйт" ХХК	4.7	7.2	153
9	"Жи ай си си" ХХК	0.5	8.1	162
	Нийт дүн	19.93	86.8	436

2013 оны тайлант үеийн хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Гэрэгэ эстимэйт” ХХК 4.20 дахин, “Вендо” ХХК 3.94 дахин, “Файн эстимэйт” ХХК 1.5 дахин, “Бест эстимэйт” ХХК 4.65 дахин, “Вендо” ХХК 3.94 дахин, “Арвижих эстимэйт” ХХК 1.53 дахин, “Жи ай си си” ХХК 16.20 тус тус өссөн байна.

Тайлант хугацаанд “Мега марз” ХХК нь санхүүгийн тайлангаа ирүүлээгүй байна.

ХІ. ДҮГНЭЛТ

Даатгалын зах зээл дээр 2013 оны 1 дүгээр улиралд үйл ажиллагаа явуулсан даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид нийт 16059.0 сая төгрөгийн орлого олсон байна. Энэхүү орлогын 15626.3 сая төгрөг буюу 97.3 хувийг ердийн даатгалын компаниуд, 233.6 сая төгрөг буюу 1.45 хувийг урт хугацааны даатгалын компани, 112.3 сая төгрөг буюу 0.70 хувийг даатгалын зуучлагч компаниуд, 86.8 сая төгрөг буюу 0.54 хувийг даатгалын хохирол үнэлэгч компаниудын олсон орлого тус тус бүрдүүлсэн байна.

2013 оны 1 дүгээр улирлын байдлаар даатгалын зах зээл дээр урт хугацааны болон ердийн даатгалын үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудын нийт хөрөнгө 104.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 46.4 тэрбум төгрөгөөр буюу 2.2 дахин өссөн байна.

Түүнчлэн тайлант үед 1.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж байгаа ч даатгалын нөөцийн сангийн нийт эзлэх хувь хэмжээ буурч, нөгөө талдаа даатгалын хохирол нөхөлтийн түвшин нэмэгдэж байна.

Даатгалын компаниуд өөрсдийн хүлээж буй болзошгүй даатгалын томоохон эрсдлийг давхар даатгагчид шилжүүлсэн байдал өмнөх оны мөн үеийнхээс 2132.8 сая төгрөгөөр буурсан.

Нөгөө талаас зарим сөрөг үзүүлэлтүүд ажиглагдаж байгаа ба тухайлбал, даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид эзлэх даатгалын нөөц сангийн хувийг авч үзэхэд 2011 оны 1 дүгээр улиралд 49.5 хувийг эзэлж байсан бол 2012 оны 1 дүгээр улиралд 44.1 хувь, 2013 оны 1 дүгээр улиралд 44.0 хувь болж тус тус буурсан байна. Өөрөөр хэлбэл даатгалын компанийн балансын нийт пассивт нөөц сангийн эзлэх хувь 2010 оноос хойш буурч, харин эзэмшигчийн өмчийн эзлэх хувь өссөн бөгөөд энэ нь нэг талаас хувь нийлүүлэгчийн хөрөнгө буюу дүрмийн сангийн өсөлт, нөгөө талаас даатгалын нөөц сангийн актуар тооцоолол хангалтгүй байгаатай холбоотой.

Даатгалын компаниудын нийт хөрөнгөнд мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, хөрөнгө оруулалтууд ихээхэн хувийг эзэлж байгаа нь даатгагчийн урт хугацаан дахь хөрөнгө оруулалтын өгөөжид сөргөөр нөлөөлөх хандлагатай байна.

ДААТГАЛЫН ГАЗРЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС